



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/01-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689 Цахим хаяг: ts.nadiii@yahoo.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1. Байгууллагын үйл ажиллагаа.....	9
3.2. Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан.....	12
4.1. Ерөнхий зүйл.....	12
4.2. Дотоод хяналт.....	12
4.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
4.4. Материаллаг байдал.....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1. Шилэн дансны мэдээлэл.....	13
5.2. Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14-15
8. Аудитаар илрүүлэлт.....	15-17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18-19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ ЭНЕРГО ОНӨААТҮГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.АЛТАНСҮХ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/07-НА-СТА-ОНА

тапай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

СЭА-2022/07-НА-СТА-ОНА

018020396

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

ийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,689,036.35	14,376,166.72
1.1.2	Дансны авлага	1,143,948,948.22	1,588,484,086.78
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	18,006,523.00	41,411,377.14
1.1.6	Бараа материал	752,742,098.84	902,057,282.97
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,918,386,606.41	2,546,328,913.61
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,914,374,180.47	20,366,914,654.43
1.2.2	Биет бус хөрөнгө	572,195,107.89	570,047,660.20
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,486,569,288.36	20,936,962,314.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,404,955,894.77	23,483,291,228.24
2.1	Өр төлбөр	7,077,222,893.58	7,887,659,663.69
2.1.1.1	Дансны өглөг	4,603,640,842.12	4,692,153,832.29
2.1.1.2	Цалингийн өглөг	104,662,169.00	91,396,397.00
2.1.1.3	Татварын өр	1,409,462,706.24	1,780,461,595.85
2.1.1.4	НДШ-ийн өглөг	924,041,812.16	1,286,489,120.23
2.1.1.5	Богино хугацаат зээл	35,415,364.06	37,158,718.32
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,077,222,893.58	7,887,659,663.69
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	144,000,000.00	109,606,462.97
2.1.2.1	Урт хугацаат зээл	144,000,000.00	109,606,462.97
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	144,000,000.00	109,606,462.97
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,221,222,893.58	7,997,266,126.66
2.3.1	Өмч: - төрийн	10,138,430,240.48	10,238,540,831.48
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,455,050,972.96	15,455,050,972.96
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(9,409,748,212.25)	(10,207,566,702.86)
2.3.11	Эздийн өмчийн дүн	16,183,733,001.19	15,486,025,101.58
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,404,955,894.77	23,483,292,228.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,236,603,321.97	6,135,951,844.69
2	Борлуулалтын өртөг	6,726,218,462.63	7,130,700,395.77
3	Нийт ашиг (алдагдал)	(1,489,615,140.66)	(994,748,551.08)
5	Хүүгийн орлого	121,366.92	
8	Бусад орлого	448,329,908.98	733,892,736.48
9	Борлуулалт, маркетингийн зардал	398,638,702.41	482,788,616.54
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,061,767.07	397,740.45
11	Санхүүгийн зардал	34,507,848.00	49,027,043.64
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(4,749,275.38)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,475,372,182.24)	(797,818,490.61)
19	Орлогын татварын зардал	12,136.60	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,475,384,318.84)	(797,818,490.61)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,475,384,318.84)	(797,818,490.61)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12 р сарын 31-ний үлдэгдэл	10,138,430,240.48	15,455,050,972.96	(7,934,363,893.41)	17,659,117,320.03
3	Залруулсан үлдэгдэл	10,138,430,240.48	15,455,050,972.96	(7,934,363,893.41)	17,659,117,320.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,475,384,318.84)	(1,475,384,318.84)
9	2020 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	10,138,430,240.48	15,455,050,972.96	(9,409,748,212.25)	16,183,733,001.19
11	Залруулсан үлдэгдэл	10,138,430,240.48	15,455,050,972.96	(9,409,748,212.25)	16,183,733,001.19
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(797,817,465.40)	(797,817,465.40)
14	Өмчид гарсан өөрчлөлт	100,110,591.00			100,110,591.00
17	2021 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	10,238,540,831.48	15,455,050,972.96	(10,207,565,677.65)	15,486,026,126.79

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,367,179,198.92	6,512,829,449.96
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,938,816,208.01	5,719,148,540.87
	Татаас, санхүүжилтийн орлого	428,000,000.00	447,090,909.09
	Бусад мөнгөн орлого	362,990.91	346,590,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,317,020,677.37	6,467,748,782.56
	Ажиллагчдад төлсөн	1,600,868,526.20	2,134,956,022.23
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		95,999,045.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,045,116,592.00	1,487,348,650.00
	Ашиглалтын зардалд төлсөн	1,163,120,072.00	1,215,624,631.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,310,760,314.82	1,326,450,816.88
	Хүүний төлбөрт төлсөн	64,425,565.81	62,081,851.17
	Татварын байгууллагад төлсөн	104,036,819.47	94,390,753.83
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	28,692,787.07	50,897,012.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	50,158,521.55	45,080,667.40
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	121,366.92	-
	Хүлээн авсан хүүний орлого	121,366.92	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(3,310,000.00)	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(3,310,000.00)	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,188,633.08)	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	58,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		58,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(88,999,999.90)	(92,393,537.03)
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(88,999,999.90)	(92,393,537.03)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(88,999,999.90)	(34,393,537.03)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(42,030,111.43)	10,687,130.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,719,147.78	3,689,036.35
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	3,689,036.35	14,376,166.72

2.5 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Сүхбаатар сум	мян.төг	4,423,116.0	5,386,395.9	963,279.9	82.1
	Цагааннуур сум	мян.төг	272,247.0	138,607.2	133,639.8	51
	Алтанбулаг сум	мян.төг	309,087.0	258,903.5	50,183.5	70
	Бугант тосгон	мян.төг	349,617.0	352,045.6	2,428.6	100.0
	Эрчим хүчний алдагдлын санхүүжилт	мян.төг	450,000.0	447,090.9	2,909.1	101
	Бусад орлого	мян.төг	40,358.0	286,801.4	246,443.4	140.00
1	Нийт борлуулалтын орлого	мян.төг	5,844,425.0	6,869,844.5	1,025,419.5	85
2	Үйл ажиллагааны зардал	мян.төг	6,890,840.0	6,888,699.1	2,140.9	100.03
	Элэгдлийн зардал	мян.төг	525,385.0	687,968.2	162,583.2	76.37
	ҮХЭХАТ, АТӨЯАТ-ын татвар	мян.төг	9,255.0	9,255.00		100.00
	Газрын төлбөр	мян.төг	479.0	479.00		100.00
	Усны нөөц	мян.төг	2,800.0	2,800.00		100.00
	Бусад татвар хураамж	мян.төг	1,200.0		1,200.0	
	Ажиллагсдын нийгмийн хамгааллын зардал	мян.төг	80,000.0	78,461.7	(1,538.3)	102
3	Нийт зардал	мян.төг	7,509,959.0	7,667,663.0	157,704.0	97.9
4	Татварын дараах ашиг алдагдал	мян.төг	(1,665,534.0)	(797,818.5)	(867,715.5)	208.76
5	Нийт төсөвт төлөх татвар	мян.төг				
	НӨАТ	мян.төг		94,390.7		-
	ААНОАТ	мян.төг				
	ХАОАТ	мян.төг				
6	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	176	167	9	105.39
7	Нийт цалингийн сан	мян.төг	2,456,843.1	2,031,411.00	113,542.1	120.94
8	Нийт авлага	мян.төг	960,000.0	1,629,895.30	669,895.3	58.90
9	Нийт өр төлбөр	мян.төг	7,800,000.0	7,977,266.1	177,266.1	97.78

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь “*Орчин үеийн техник технологи нэвтрүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ явуулж, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр найдвартай ханган, эдийн засгийн алдагдлыг бууруулах замаар салбартаа тэргүүлэгч байгууллага болно*” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах.
- Гадаад дотоод худалдаа.
- Туслах үйлдвэрлэл хөгжүүлэх.
- Гуанз, цайны газрын үйлчилгээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар”-ын статустай бүртгэгдэж, 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2002 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д “*Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах***”, 19 дүгээр зүйл “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх “*Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний

өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоол “ТБОНӨБАУ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай” гэх мэт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,689.0	14,376.2	10,687.2
Дансны авлага	1,143,949.0	1,588,484.1	444,535.1
Татвар, НДШ-ийн авлага	18,006.5	41,411.4	23,404.9
Бараа материал	752,742.0	902,057.3	149,315.3
Үндсэн хөрөнгө	20,914,374.2	20,366,914.6	(547,459.6)
Биет бус хөрөнгө	572,195.1	570,047.7	(2,147.4)
Нийт хөрөнгө	23,404,955.8	23,483,291.2	78,335.4
Өр төлбөр	7,077,222.9	7,887,659.7	810,436.8
Урт хугацаат зээл	144,000.0	109,606.5	(34,393.5)
Эздийн өмч	10,138,430.2	10,238,540.8	100,110.6
Эздийн өмчийн бусад хэсэг	15,455,050.9	15,455,050.9	-
Хуримтлагдсан ашиг	(9,409,748.2)	(10,207,566.7)	(797,818.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	23,404,955.8	23,483,291.2	78,336.4

Байгууллагын касс 123.8 мянган төгрөг, банкин дахь харилцах дансанд 14,252.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 10,687.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд касс болон харилцахаар 6,570,829.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 6,560,142.3 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Дансны авлага 1,588,484.1 мянган төгрөг болж, 444,535.1 мянган төгрөгөөр өссөн нь дулааны үнийг “Эрчим хүчний зохицуулах зөвлөл”-өөс шинэчлэн тогтоосон үнэ тарифаар тооцож, төсөвт байгууллагуудаас нэхэмжлэн авлага үүсгэснээс шалтгаалсан байна.

Татвар, НДШ-ийн авлага 23,404.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 149,315.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 1,500,990.5 мянган төгрөгийн нүүрс, 977,231.3 мянган төгрөгийн бусад түүхий эд материал худалдан авч, 2,328,905.5 мянган төгрөгийн материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс /анхны өртгөөр/ 24,089,010.8 мянган төгрөг болж 106,601.7 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын данснаас 43,000.0 төгрөгийн хөрөнгө шилжүүлж авсан, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 100,110.6 мянган төгрөгийн дулааны шугам хоолойг барилга байгууламжийн дансанд үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн болон аймгийн ИТХТ-ийн 2021 оны 12 сарын 28-ны өдрийн 122 дугаар тогтоолоор 36,508.9 мянган төгрөгийн 3 ширхэг тээврийн хэрэгсэл акталснаас голлон шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 810,436.8 мянган төгрөгөөр өссөн нь дансны өглөг 132,001.8 мянган төгрөгөөр, бусад өглөг 115,231.3 мянган төгрөгөөр, НӨАТ-ын өглөг 362,447.3 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын өглөг 150,779.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан алдагдал 10,207,566.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 797,818.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 10,238,540.8 мянган төгрөг болж, 100,110.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнгээс шалтгаалжээ.

3.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, аймгийн ИТХ Засаг даргаар батлуулаагүй бөгөөд харин захирлын 2021 оны А/04 дүгээр тушаалаар тайлант оны орлогыг **5,844,425.0** мянган төгрөгөөр, зардлыг **7,506,661.0** мянга төгрөгөөр баталж, 1,662,236.0 мянган төгрөгийн алдагдал хүлээхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр **6,869,844.6** мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, **7,667,663.1** мянган төгрөгийн зардал гаргаж, 797,818.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 6,869,844.6 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1,02,412.6 мянган төгрөг буюу 17.5 хувиар давж биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 7,667,663.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 161,001.0 мянган төгрөг буюу 2.1 хувиар өссөн нь нүүрсний үнэ нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант оны алдагдал төлөвлөснөөс 864,418.6 мянган төгрөгөөр бага буюу 797,818.5 мянган төгрөг болсон нь төр төсвийн байгууллагуудын дулааны үнийг шинэчилсэн тарифаар тооцож нэхэмжлэн, авлага үүсгэснээс шалтгаалсан байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын /цаашид “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд үнэн зөв тайлагнах тухай зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит”ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд үйлдвэрийн газрын өөрийн дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь аймгийн ТЕЗ-ийн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Эрчим хүчний зохицуулах хорооноос хяналт шалгалт хийж, дулааны төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан үнэ тарифаар мөрдөж ажиллах тухай 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 60-07-001/29 тоот албан шаардлагыг Сэлэнгэ аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

4.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 7,662,912.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 76,629.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 53,640.4 мянган төгрөгөөр тогтоосон.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1- 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь тайлант онд 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. *“Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”* гэсэн заалтыг зөрчин хаврын баярын арга хэмжээг тохиолдуулан 1,670.0 мянган төгрөгийг шагнал, урамшуулал, бэлэг дурсгалд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 198,909.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 8,417.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	3	198,909.9	3	198,909.9	100.0
Зөвлөмж	5	8,417.7	4	8,417.7	80.0
Нийт дүн	8	207,327.6	7	207,327.6	87.5

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг “0” үлдэгдэлтэй болсон 355,443.1 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 189 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа тул НББОУС-ын Үндсэн хөрөнгө 16-ын 34-д *“... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс ихээхэн ялгаатай бол дахин үнэлээг зайлшгүй хийнэ”* гэсэн заалтын дагуу “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглахаар бол дахин үнэлэх эсвэл

акталж устгах тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлсэн эсэхийг тулган баталгаажуулах шаардлагатай.

- 2021 онд **6,869,844.6** мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлж, **7,667,663.1** мянган төгрөгийн зардал гарган, үйл ажиллагааны үр дүнгээр 797,818.5 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” тодорхойлолтыг хангахгүй байгаа учир санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт хийх замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүлээх, өөрийгөө санхүүжүүлэх нөөц боломжийг бүрдүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтийг шалгах шаардлагатай.
- Мөнгөн хөрөнгийн дутагдлаас шалтгаалан ажилтнуудын цалинг тогтоосон хугацаанд нь олгож чадахгүйд хүрч, Төрийн банктай 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулан, цалин тавьж олгох зорилгоор сар бүр зээл авч ирсэн байна. Гэрээнд заагдсаны дагуу урьдчилгааг 3 хоногийн дотор хаах үүргээ биелүүлээгүйн улмаас 2021 онд 2,222.1 мянган төгрөгийн алданги төлсөн байна. Мөн 5 хувь хүнээс богино хугацаагаар 36,336.5 мянган төгрөг зээлж, тодорхой хэмжээний хүүгийн зардал гаргасан тул дараагийн аудитаар борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлсэн болон мөнгөн хөрөнгийн дутагдлаас гарах талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг нарийвчлан авч үзэх нь зүйтэй юм.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 298,326.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 73,800.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 349.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 41,765.5 мянган төгрөгийн зөрчил албан шаардлага, 182,411.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй материаллаг 42,115.1 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 53,640.4 мянган төгрөгийн түвшнээс 11,525.3 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 73,800.0 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Дансны авлагын дэлгэрэнгүй тайланд 21,545.1 мянган төгрөгийн авлагыг хасах тэмдэгтэйгээр бууруулж бүртгэсэн,
- Үл хөдлөх хөрөнгийн татвар 9,255.0 мянган төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэснийг удирдлагын зардлаар залруулав.
- Үндсэн хөрөнгийн чанартай 43,000.0 мянган төгрөгийн бутлагч машиныг материалын дансанд бүртгэснийг машин тоног төхөөрөмжийн дансанд залруулж бүртгэв.

8.2 Төлбөрийн акт

1.Сахилгын шийтгэлтэй 3 ажилтанд үр дүнгийн урамшуулал 349.6 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх “*Сахилгын шийтгэл ноогдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно*” , тус үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7-р зүйлийн 7.6 дахь “*Сахилгын шийтгэл ноогдуулсан ажилтанд үр дүнгийн шагналт цалин шийтгэл ноогдуулсан тухайн сард нь олгохгүй*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй ажилтанд олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

8.3 Албан шаардлага.

1. Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг **холбогдох байгууллага, албан тушаалтнаар бус** үйлдвэрийн газрын **дарга өөрөө** баталсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

2. Шууд худалдан авах босго үнээс давсан 20,247.5 мянган төгрөгийн өртөг бүхий нормын хувцас /*хөвөнтэй өмд цамц, зуны хослол, хөвөнтэй бээлий зэрэг оёмол хувцас*/, 21,517.5 мянган төгрөгийн өртөг бүхий мах /*үхрийн мах-20,266.0, хонины мах-4,251.5 мянган төгрөг*/-ны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “*Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно*” гэсэн заалт болон Засгийн газрын 2013 оны 68, 2021 оны 124 дүгээр тогтоолуудыг тус тус зөрчсөн бөгөөд “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, эрхийн актыг баримтлах албан шаардлага хүргүүлэх.

8. 4 Зөвлөмж

1.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн их хэмжээний өр төлбөртэйгөөс шалтгаалан ажилтнуудын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 100.0 хувь буюу 41,411.4 мянган төгрөгийг байгууллагаас төлж барагдуулан, НДШ-ийн авлагаар тайлагнасан боловч тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*...тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Зөвлөмж: 2022 оны эхний хагас жилд багтаан авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулах.

2.1 Илрүүлэлт Борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 141,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь татварын хяналт шалгалтаар акт, өр төлбөр тавигдах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.6-д “*... тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах*”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Албан татварыг доор дурдсан журмаар ногдуулна8.1.1-д “*бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Зөвлөмж: 2022 оны эхний хагас жилд багтаан тооцоо нийлж, залруулж бүртгэх, цаашид холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1	“Сэлэнгэ энерго” ОНААТҮГ	СЭА-2022/06-НА- СТА-ОНА	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин шагнал, урамшуулал, бэлэг дурсгал олгосон	1	1,670.0			1	1,670.0					
2	“Сэлэнгэ энерго” ОНААТҮГ	СЭА-2022/06-НА- СТА-ОНА	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 мэдээллийг огт мэдээлээгүй.	1					1					
ДҮН				2	1,670.0			1	1,670.0	1	-	-	-	
НИЙТ ДҮН				10	299,996.5	3	73,800.0	2	2,019.6	3	41,765.5		2	182,411.4